



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2020-2024 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төлөвлөгөө баталсан:

Аймгийн Засаг дарга

(албан тушаал)



Төсвийн Ерөнхийлөн захирагч

Г.Батзам

(гарын үсэг)

2021 оны дүгээр сарын -ний өдөр

Төлөвлөгөө боловсруулсан:

Байгаль орчин, аялал жуулчлалын
газрын дарга

(албан тушаал)



Д.Мөнх-Эрдэнэ

(гарын үсэг)

2021 оны дүгээр сарын -ний өдөр

**Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021-2024 оны стратеги
төлөвлөгөөний бүтэц, агуулга**

Бүлэг 1. Нийтлэг үндэслэл	3-9
Бүлэг 2. Мандатын шинжилгээ	10-11
Бүлэг 3. Алсын хараа	12
Бүлэг 4. Эрхэм зорилго	12
Бүлэг 5. Орчны шинжилгээ	12-15
Бүлэг 6. Стратегийн зорилго	16
Бүлэг 7. Стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, стратеги.....	17-26
Бүлэг 8. Стратегийн зорилго ба Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын байгууллагын бүтцийн уялдаа, зураглал.....	
Бүлэг 9. Хавсралт	

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Практик хэрэгцээ, шаардлага

Монгол орон байгалийн унаган төрхөө харьцангуй хэвээр хадгалж үлдсэн дэлхийн цөөн орны нэг боловч хотжилт, үйлдвэржилт зэрэг хүний үйл ажиллагаа болон байгаль, цаг агаарын хувьсал өөрчлөлтөөс шалтгаалан байгаль орчин доройтон бохирдох, байгалийн нөөц баялаг хомстох улмаар зарим нутагт экосистемийн тэнцвэр алдагдах байдал ажиглагдах болсон.


Говьсүмбэр аймаг нь Монгол улсын төвийн бүсийн зүүн өмнөд хэсэгт хойд өргөргийн 46057'- 47002', зүүн уртрагийн 1070 57'- 1090 04'-т байрладаг. Улаанбаатар хотоос зүүн өмнө зүгт 250 км-ийн зайд оршдог.

Хойд талаараа Төв аймгийн Баянжаргалан, Баянцагаан, Баян сумдтай, зүүн ба зүүн хойд хэсгээрээ Хэнтий аймгийн Дархан, Дэлгэрхаан сумдтай, баруун болон баруун өмнөд хэсгээрээ Дундговь аймгийн Баянжаргалан, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Дорноговь аймгийн Даланжаргалан сумдтай тус тус хиллэдэг. Хамгийн өндөр цэг нь далайн түвшнээс дээш 1695.0 м өргөгдсөн Оцол уул, нам цэг нь далайн түвшнээс дээш 1175.0 м-т орших Хэрлэн голын нам татам болно. Ихэнх нутаг нь далайн түвшнээс дээш 1300-1400 м-т орших толгодлог гадаргаас бүрдэнэ. Түүнээс гадна нутаг дэвсгэрийн хувьд бага талбайтай, уулсын ихэнх нь зүүн хэсэгт төвлөрсөн, аймгийн төв Чойр хот нь байгалийн 2 бүсийн зааг болж байдаг онцлогтой юм.

Талбай: 5,5 мянган километр хавтгай дөрвөлжин нутаг дэвсгэртэй.

Цаг уур: Далайн түвшнээс дээш 1000-1200 метрийн өндөрт оршдог говь, тал хээр хосолсон эх газрын эрс тэс уур амьсгалтай нутаг юм. Говьсүмбэр аймагт жилд унах тунадасны хэмжээ говийн бүсийнхээс илүү /дунджаар 200-250 мм/ бөгөөд температурын ялгаа зундаа +370, өвөл-370 градус байдаг. Говьсүмбэр аймаг нь нүүрс, тоосгоны шавар, эрдэс будаг, хайлуур жонш, шохойн болон бал чулууны байгалийн баялаг нөөцтэй өгөөмөр баян нутаг юм.

Говьсүмбэр аймаг Монгол Улсын эдийн засагт томоохон хувь нэмэр оруулах боломжтой. Учир нь дэд бүтэц, зам харилцаа гээд бусад өрсөлдөх чадвар, эдийн засгийн хүрээгээрээ ямар ч үйл ажиллагаа явуулах боломж нь бүрдсэн газар. Дэд бүтцээ дагаж хөгжих хүрээнд дэд бүтэц, тээвэр ложистик, экспорт, импортын тээврийн үйл ажиллагаа, худалдаа үйлдвэрлэлийн салбар болон аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилттой.



Суурин хүн амын тоо

Үзүүлэлт:	2019 он	2020 он
Бүгд	17445	18008
Эрэгтэй	8796	9068
Эмэгтэй	8649	8940
Хот	10427	10766
Хөдөө	7018	7242

БАЙГАЛЬ ОРЧИН

2017 онд Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал 9.8 сая төгрөгөөр Биологийн төрөл зүйлийн судалгаа хийгдсэн. Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрт 7 багийн 19 овог 26 төрөл зүйлийн шавж, бух сугас *Leuciscus idus* зүйлийн загас, 86 зүйлийн шувууг бүртгэгдсэн, шувуудаас 20 зүйл нь суурин амьдралтай, 25 зүйл нь нүүдлийн үрждэг, 41 зүйл нь нүүдлийн үедээ түр саатан, дайран өнгөрдөг, мөн 46 зүйл нь ус намгийн шувууд, 18 зүйлийн хөхтөн амьтан бүрдэгдсэн байдаг 43 овог, 136 төрөл, 240 зүйл ургамал бүртгэгдсэн байдаг.

2019 онд БХНСАХЗ 10.3 сая төгрөгөөр Аймгийн “Ерөнхий агнуур зохион байгуулалт, ан агнуурын менежментийн төлөвлөгөө, Хаялага нуурын, загасны судалгаа хийсгдсэн. 2020 онд БХНСАХЗ-ын 8 сая төгрөгөөр хийгдсэн Цөлжилтийн судалгаагаар аймгийн нийт газар нутгийн 99.2 хувь нь цөлжилт, газрын доройтолд өртсөн байна гэсэн дүгнэлт гарсан.

Уур амьсгалын өөрчлөлт: Хүний болон байгалийн хүчин зүйлээс болж манай аймагт жилд орох хур тунадасны багасаж 180-220 мм болж байна. Судалгааны бүс нутагт жилийн дундаж салхины хурд цаг уурын харуул, өртөөдийн флюгерийн (газраас дээш 10 м-ийн өндөрт) хэмжилтээр 3,2-3,5 м/с орчим, шороон шуургатай өдрийн тоо жил бүр 5-6 хоногоор нэмэгдэж уур амьсгалийн өөрчлөлт бий болж байна.

Биологийн олон янз байдал: Нэн ховор, ховор амьтанг хамгааллах зорилгоор 70 тоо толгой монгол тарвага сэргээн нутагшуулж, өвөлжилт хүндрэлтэй үед Чойрын богд уул нутагшдаг аргаль, хонинд 534 боодол өвс, 5.5 тонн хужир тавих ажлыг зохион байгуулж ажилласан. Цаашид ховордсон амьтан, ургамлыг судалгаан дээр үндэслэн нутагшуулж, тарималжуулна. Зэрлэг туруутан амьтдын популяцид сөрөг нөлөө үзүүлж буй хүчин зүйл бол УБ-Замын үүд чиглэлийн төмөр зам, олон улсын чанартай А0101 хатуу хучилттай авто зам, малын тоо толгой хэт өсөж бэлчээрийн даац хэтэрч доройтолд орсон зэрэг болно.

2014-2020 оны хооронд нийт аймгийн хэмжээнд нийт 93 776 ширхэг мод бут тарьж, модны амьдралт 80 хувьтай байна. Мөн орон нутгийн ногоон бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэн улсын чанартай авто замын дагуу 35.5 га ойн зурвас, 26.8 га талбайд цэцэрлэгт хүрээлэн байгуулсан. Ард иргэдийн оролцоотойгоор мод тарьж ногоон байгууламж нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлэн Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар журам батлуулан ажиллаж байгаа бөгөөд сүүлийн 6 жилийн хугацаанд нийт давхардсан тоогоор 5 аж ахуйн нэгж байгууллага, 65 иргэний нийтийн болон өөрийн эзэмшлийн хашаандаа 10299 ширхэг мод, сөөг тарьж 68.9 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон.

БНХАУ-ын Экологийн танхим болон МУ-ын Газарзүй геоэкологийн хүрээлэнтэй хамтран 2019 онд 22 га талбайд аймгийн цөлжилтийн судалгааны төв бий болгон ажиллаж байна. 2020 онд аймгийн хэмжээнд цөлжилтийн судалгаа хийгдсэн ба уг судалгаагаар нийт нутагт дэвсгэрийн 99.2 хувь цөлжилттэй гэсэн дүгнэлт гаргасан.

Хэрлэн голын дагуу 45 га байгалийн ойн сан, Улсын чанартай авто замын дагуу 35.6 га талбайд ойн зурвас, нийтийн эзэмшлийн 26.8 га талбайд бичил болон цэцэрлэгт хүрээлэн байгуулсан. Цаашдаа төсвийг нэмэгдүүлэх ойн шаардлагатай. 2024 оны аймгийн үндсэн чиглэл, Чойр хотын ерөнхий төлөвлөгөөнд **25 га талбайд** агро-ойжуулалт бий болгох зорилт тавин ажиллаж байна.



Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрийн газрын нэгдмэл сангийн ангиллаар авч үзвэл 2020 онд нийт нутгийн 86.8 хувийг хөдөө аж ахуйн газар, 10.8 хувийг улсын тусгай хэрэгцээний газар, 1.2 хувийг хот тосгон, бусад суурин газар, 1.0 хувийг зам, шугам, сүлжээний газар, 0.2 хувийг усны сан бүхий газар эзэлж байна. Гадаргын усны 2020 оны тооллогоор 4 гол горхи, 1 рашаан, 4 булаг шанд, 6 нуур, тойром хамрагдсан.

Говьсүмбэр аймгийн газрын нэгдмэл сан

№	Ангилал	2020 он /га/
1	Нийт талбайн хэмжээ	554180.0
2	ХАА-н газар	480874.2
3	Хот, суурин газар	6663.3
4	Зам, шугам сүлжээ	5442.5
5	Усан сан бүхий газар	1538.0
6	Улсын тусгай хэрэгцээний газар	59662.0

Манай аймагт хуучин Орос цэргийн анги байрлаж байсан бөгөөд 1990-ээд оны үе буюу Орос цэргийн анги нүүсэн цагаас эхлэн орон нутгийн иргэд эзэнгүй орхигдож үлдсэн барилга байгууламж, барилгын суурь, газар доорх байгууламж, цэвэр бохир усны шугам сүлжээ зэрэг газруудыг ухаж авсанаас үүсэн их хэмжээний барилгын туурь хаягдал, ухмал нүхнүүд үлдэж орчныг механик бохирдлоор ихээр бохирдуулсан байдаг.

Хохирол учирсан талбай /га-гаар/

№	Ангилал	Аймаг /га/	Сум		
			Сүмбэр	Баянтал	Шивээговь
1	Нийт талбайн хэмжээ	51029.3	40002.3	10004.0	1023.0
2	Тариалангийн газарт	-	-	-	-
3	Бэлчээр ба бусад	51000.0	40000.0	10000.0	1000.0

	өвслөг ургамалт газарт				
4	Хот, суурин газарт	9.3	2.3	4.0	3.0
5	Усан сан бүхий газар	-	-	-	-
6	Ухагдаж эвдэрсэн газар	20.0	-	-	20.0

Чойр хотын хүн амын төвлөрөл ихсэхийн хэрээр цэвэрлэх байгууламж барих зайлшгүй шаардлагатай болсон тул 2006 онд Байгалийн аргаар байгальд нэвчүүлэх технологи бүхий 1500м³/хоног хүчин чадалтай 4 карттай цэвэрлэх байгууламжийг барьж ашиглалтанд оруулж өнөөдрийг хүртэл ашиглаж байна.

Ариутгах татуурга болон цэвэрлэх байгууламжийн одоо ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж: Цэвэрлэх байгууламж нь анх ашиглалтанд орохдоо механик болон биологийн аргаар бохир усыг цэвэрлэхээр байгуулагдсан боловч одоогийн байдлаар зөвхөн биологийн аргаар цэвэрлэж байна. Энэ аргаар жилд нийт 66988,6 мян.м³ бохир ус цэвэрлэж, цэвэршүүлсэн бохир усыг хөрсөнд шингээх аргаар хатаадаг. **Ариутгах татуургын жилийн нийт хэрэглээ:** 1200 айл өрх, 49 аж ахуй нэгж байгууллага, томоохон цайны газар, үйлдвэрийн газруудын бохир усыг зөөврийн автомашин, төвлөрсөн шугам сүлжээгээр татан зайлуулж байна. Манай аймгийн усны чанар тааруу, хатуулаг ихтэй учир усыг цэвэршүүлж хэрэглэх шаардлага гардаг. Тиймээс улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хатуулаг ихтэй ус хэрэглэж байгаа нэгдүгээр багт цэвэр усны шугамын эх үүсвэр дээр шинэ тоног төхөөрөмж суурилуулсан.

Тулгамдаж байгаа асуудал: Говьсүмбэр аймгийн хүн амын төвлөрөл нэмэгдэхийн хэрээр цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинэчилэн сайжруулах зайлшгүй шаардлага тулгарч байна.

Одоо ашиглагдаж байгаа цэвэрлэх байгууламж нь технологийн хувьд хуучирсан. Зарим далан нь нурж эвдэрсэн. Цэвэрлэгээний үр дүн стандартын шаардлага хангадаггүй. Дээрх арга нь хөрсний бохирдол үүсгэх, байршлын хувьд хот суурин газартаа ойр байрладаг тул агаарын бохирдол, халдварт өвчин үүсэх зэрэг нөлөөлөл ихсэх төлөвтэй байна. Хоногт 196,1м³ бохир усыг дахин ашиглалтгүйгээр байгалд шууд хаяж байгаа нь усны нөөц ба говийн бүсийн хувьд анхаарууштай асуудал болж байна.

Жич: Говьсүмбэр аймгийн Хонхор хотхон болон төмөр замын район нь бохир усаа байгальд ил задгай хиймэл нуур хэлбэрээр хаядаг. Аймгийн төвд маш ойрхон байрладаг. Халдварт өвчин гаргах өндөр магадлалтай зэрэг асуудлуудыг энэхүү цэвэрлэх байгууламж баригдсанаар цогцоор нь шийдвэрлэх боломжтой болох юм.



Ус хангамж:

Аймгийн төвийн усан хангамж нь "Умард говийн гүвээт халхын дундад талын сав газар"-ын Тэрэгтийн газрын доорх цэнгэг усны ордоос ус ашиглаж байна. Аймгийн төвийн Найрамдал хотхоны 49 аж ахуйн нэгж байгууллага, 1200 айл, өрхөд дулаан, халуун хүйтэн усаар хангаж, бохир ус татан зайлуулах үйлчилгээ үзүүлдэг. Аймгийн Онцгой байдлын хэлтэс гал унтраах зориулалтаар, Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар мод услах зориулалтаар усаар хангаж байна.

Хог хаягдал:

Говьсүмбэр аймгийн хэмжээнд 2020 онд 16647.1 тн энгийн хог хаягдал тээвэрлэгдсэн бол үүнээс Сүмбэр сумын хэмжээнд 12595 тн энгийн хог хаягдал төвлөрсөн цэгт тээвэрлэгдсэн байна. Үүнээс 60 орчим хувийг нь дахин боловсруулах боломжтой боловч 0.1 хувийг 2020 онд дахин боловсруулах үйлдвэрт зөөвөрлөгдсөн байна. 2021 оны төлөвлөгөөндөө 1 хувийг дахин ашиглах болон 3 цэгт дахивар хаягдал авах цех ажиллуулах зорилт тавин ажиллаж байна.

Манай аймагт одоогоор дахин боловсруулах үйлдвэр, хоёрдогч түүхий эд авах цехийн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, ААНБ байхгүй. Аюултай хог хаягдлын түр хадгалах байгууламж барих газрын асуудлыг шийдвэрлэж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийхээр төлөвлөөд байна.

Ашигт малтмал

Говьсүмбэр аймгийн хэмжээнд ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 7 аж ахуйн нэгж, хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 3 аж ахуйн нэгж бүртгэлтэй байгаагаас ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Шивээ-Овоо” ХК тогтмол үйл ажиллагаа явуулж нүүрс олборлож байна. Тус уурхай нь жилдээ 4.6 сая.м³ хөрс хуулж, 2.0 сая.тн нүүрс олборлох хүчин чадалтай бөгөөд Монгол улсын дотоодын нүүрсний хэрэгцээний 30.0%, “ДЦС-4” ТӨХК-ийн хэрэгцээний 50.9%-ийг дангаараа хангаж байна. Нөхөн сэргээлтийг хуулийн дагуу хийж гүйцэтгэж байна.

Аялал жуулчлал: Говьсүмбэр аймаг нь эртнээс Монгол улсын замын сүлжээний томоохон зангилаа газрын нэг байсан бөгөөд түүхэн цайны зам, гүнжийн зам, Урд хойд хөршийг холбосон цахилгаан мэдээний анхны шугам манай аймгийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрдөг байсан түүхтэй бол өнөө үед ч манай аймгийн нутаг дэвсгэрээр Москва-Улаанбаатар-Бээжинг холбосон олон улсын транс сибирийн төмөр зам ОХУ-БНХАУ-ыг холбосон босоо тэнхлэгийн авто зам, агаарын нислэгийн замууд дайран өнгөрч байна.

Хэдийгээр манай аймагт аялал жуулчлал төдийлөн хөгжөөгүй боловч “Боржигин” түмний өлгий нутаг, боржигины өв соёл, зан заншлыг агуулсан түүхэн уламжлалаа сэргээн, таниулж, байгалийн болон түүхийн дурсгалт газруудаа олон нийтэд сурталчилан таниулах зорилгоор эвент болон Боржигин соёл уламжлалтай холбоотой арга хэмжээнүүдийг тогтмолжуулах нь аялал жуулчлалыг хөгжүүлэх томоохон хөшүүрэг болох юм.

Манай аймгаар Хэнтий-Өмнөговь, Дорноговийн Их нарт, Хамрын хийдийг чиглэсэн аялал жуулчлалын маршрутын дагуу аялагчид дайран өнгөрдөг учир стандартын түр буудаллах цэг байгуулах, жуулчны бааз, зочид буудал, зоогийн газрын чанар, стандартыг сайжруулах, хүрэлцээг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын тур оператор, тур агентын байгууллагатай хамтран аяллын бүтээгдэхүүн бий болгох, цаашлаад гадаадын жуулчид хүлээн авах нөхцлийг бүрдүүлэх нь зайлшгүй авч хэрэгжүүлэх арга хэмжээ юм.

Мөн хил залгаа Хэнтий, Дундговь, Дорноговь, Сүхбаатар аймгуудадтай бүсчилсэн тусгай сонирхлын аялал жуулчлалын маршрут тогтоох нь манай аймгийн хувьд түүх соёлын өвөө сурталчлах, нутгийн иргэдийг аялал жуулчлалд татан оролцуулахад таатай нөхцөл бүрдэх юм.

Аймгийн хэмжээнд 2017 -2020 оны хооронд ирсэн жуулчдын тоон мэдээллийг графикаар үзүүлэв.



Дээрх графикаас харахад 4 жилийн байдлаар ирсэн гадаадын жуулчдын тоо 357, дотоодын жуулчдын тоо 28525 байгаа нь манай аймгийн хувьд дотоодын жуулчдыг татах, тэдгээрт зориулсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь хамгийн оновчтой төлөвлөлт болох юм.

Тусгай хамгаалалттай газар нутаг

Говьсүмбэр аймаг нь 5.5 мянган км² газар нутагтай. Аймгийн хэмжээнд Улсын тусгай хамгаалалттай “Чойрын богд уул” байгалийн нөөц газар 5265 га, аймгийн болон сумын тусгай хамгаалалтанд нийт 17 газрыг авсан бөгөөд нийт талбайн хэмжээ 203804.99 га юм.

Аймгийн хэмжээнд авсан тусгай хамгаалалттай газар нутаг нийт нутаг дэвсгэрийн 37 хувийг эзэлж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд тус аймгийн Чойрын богд уул байгалийн нөөц газрын одоогийн байгаа талбайн хэмжээг 10 дахин нэмэгдүүлж авахаар холбогдох судалгааны материал, аймаг орон нутгийн тогтоол шийдвэрийг хүргүүлээд байна.

Улсын тусгай хамгаалалттай газар нутагт тулгамждаж байгаа асуудлууд нь бэлчээрийн мал аж ахуйн хэт төвлөрөл, малын тоо толгой ихэссэнтэй холбоотойгоор ховор ан, амьтдын өсөж үржих нутаг хумигдах, байгалийн унаган төрх, ургамалжилт сийрэгжих асуудлууд үүсэж байгаа тул орчны бүсийн зөвлөл байгуулах, тусгай хамгаалалттай газруудад нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, хяналт тавих ажлыг зохион байгуулах нь зүйтэй юм.

Сургалт сурталчилгаа

2017-2019 онуудад иргэдийн нэмэгдэж байгаа бөгөөд 2020 онд ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан буурсан үзүүлэлттэй байна./ Графикаар үзүүлэв/



2017-2020 оны хооронд бүх нийтийн экологийн боловсрол, тогтвортой хөгжлийн боловсролыг олгох ажлын хүрээнд 46 арга хэмжээ зохион байгуулж, 3448 иргэнийг хамруулсан байна.

Цаашид нас, насны ангилалд тохирсон мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлж ажиллах зүйтэй юм.

1.2 Бодлого, эрх зүйн үндэслэл:

Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах, дээрх хөгжлийн үзүүлэлтүүдийг тогтвортой хангах зорилгоор Монгол улсын урт хугацааны бодлого “Алсын хараа-2050”, Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд “Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль”-ийн дагуу аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор “Говьсүмбэр аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, 05 дугаар тогтоолоор “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг тус тус батлан бодлогын 4 зорилтын хүрээнд үйл ажиллагаа, арга хэмжээгээ төлөвлөн хэрэгжүүлж байна. “Аймгийн стратеги төлөвлөгөө”-ний үндсэн зорилт, арга хэмжээг төлөвлөхдөө аймгийн дунд болон богино хугацааны дээрх бодлогын баримт бичгийг баримтлан, уялдуулан боловсрууллаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт өнөөгийн байдлаар байгаль орчныг хамгаалах, газар, ус, байгалийн ургамал, ой, ан агнуур, агаар, хог хаягдал, химийн бодис, аялал жуулчлал зэрэг 36 хууль, 3 бодлого, 17 үндэсний хөтөлбөр, 1 менежментийн төлөвлөгөө зэрэг төрөөс байгаль, орчныг хамгаалах талаар баримтлах бодлого, стратеги, хууль, тогтоомжийг Улсын Их Хурал, Засгийн газраар батлуулж, байгалийн нөөц ашиглалтыг эдийн засгийн үнэлгээ, төлбөртэй болгох, байгалийн нөөц ашиглагч нь хамгаалагч, бохирдуулагч нь төлөгч байх зарчмыг хэрэгжүүлэхэд онцгойлон анхаарч ажиллаж байна.

Салбарын ирэх 4 жилийн стратеги төлөвлөгөөнд хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэх, салбарын хэмжээнд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зорилго, стратегийг боловсруулж тусгасан.

Стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”, “Стратеги төлөвлөгөөний загвар”-ыг баримталсан.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Мандатыг тодорхойлохдоо 2020 онд хийгдсэн чиг үүргийн шинжилгээний үр дүнд тулгуурлан Монгол Улсын Үндсэн хууль болон Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын салбарын шууд хамаарах 36 хууль, салбарын эрхлэх асуудал, төсөв санхүү зэрэг нийт 94 хуулийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон салбарын бусад байгууллагуудад хуулиар олгосон чиг үүргийг хамруулан авч үзэж, дараах дөрвөн алхмын хүрээнд шинжилгээг хийсэн. Үүнд:

1. Хууль тогтоомжоор Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын байгууллагын үйл ажиллагаанд хамаарах чиг үүргийг тодорхойлох;
2. Тухайн чиг үүргүүдийг үйл ажиллагааны чиглэлээр ангилах;
3. Салбар хоорондын холбогдогч талуудын оролцоог тодорхойлох;
4. Чиг үүргийн хэрэгжилтийн байдлыг тодорхойлох.

Мандатын шинжилгээний үр дүнд 3 ерөнхий чиг үүрэг, 11 үндсэн чиг үүрэг, 47 дэд чиг үүргийг нарийвчлан тодорхойлж, доорх хүснэгтээр үр дүнг нэгтгэсэн.

МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮСНЭГТ

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		130
Үүнээс:	Тухайн салбарын хуулийн тоо	36
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо	94
Ерөнхий чиг үүрэг-1: Байгаль орчныг хамгаалах		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Газар, ландшафт	1. Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих	Аймгийн ЗДТГ Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл
	2. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг өргөжүүлэх, хамгаалалтын менежментийг хэрэгжүүлэх	
	3. Тусгай хамгаалалттай газар нутгийн газрын харилцааг зохицуулах	
	4. Газар зохион байгуулалт, газрын нөөцийн удирдлагын бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	
	5. Нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгаалал, байгалийн нөөцийн хамтын менежментийг хэрэгжүүлэх	
ҮЧҮ-2: Усны бодлого	6. Усны бодлого, хууль тогтоомж, норм, стандартыг хэрэгжүүлэх, төсөв, хөрөнгө оруулалтыг төлөвлөх	Оролцогчид: ХОХБТХ, ХХААГ, УЦУОША, ГХБХБГ, Усаар хангагч байгууллагууд, Сумдын ЗДТГ, иргэд, бусад төрийн болон ТББ
	7. Усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хамгаалалтад авах	
	8. Усны хайгуул, судалгаа хийх ажлыг зохион байгуулах, зохицуулах, нөөц батлах	
	9. Усны тоо бүртгэл, статистик мэдээлэл, кадастр, улс орон нутгийн усны мэдээллийн сан бүрдүүлэх	
	10. Ус ашиглалтыг зохицуулах, хяналт тавих	
ҮЧҮ-3: Ногоон байгууламж	11. Хэрлэн гол дагуу байрших байгалийн ойн санг хамгаалах	Гүйцэтгэх үүрэгтэй Сум дундын ойн анги
	12. Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн хамгаалалтыг сайжруулж, нэмэгдүүлэх	
	13. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор мод бут тарьсан иргэн, ААНБ-д мөнгөн урамшуулал олгох.	
	14. нэн ховор, ховор амьтан, ургамлын нөөц, ховордсон зүйлийг хамгаалж, нутагшуулж,	Иргэдийн нөхөрлөл

ҮЧҮ-4: Биологийн олон янз байдлын бодлого	тарималжуулах.	Иргэдийн нөхөрлөл Аймгийн ЗДТГ СЗДТГ Хувийн хэвшил
	16. Биологийн олон янз байдлын бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	
	17. нэн ховор, ховор амьтан, ургамлын нөөц, ховордсон зүйлийг хамгаалж, нутагшуулж, тарималжуулах.	
Ерөнхий чиг үүрэг-2: Орчны бохирдол, доройтлыг бууруулах		
ҮЧҮ-6: Ногоон хөгжил, тогтвортой хөгжил	18. Тогтвортой хөгжлийг дэмжих ногоон хөгжлийн бодлого, хууль тогтоомж бхэрэгжүүлэх	ХОХБТХ, БСУГ, ГХБХБГ, Сумдын ЗДТГ, иргэд, бусад төрийн болон ТББ
	19. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогын хэрэгжилтийг хангах	
	20. Хаягдал багатай, хэмнэлттэй цэвэр технологи, тогтвортой үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах	
	21. Аж ахуйн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, сөрөг нөлөөллийг бууруулах	
	22. Тогтвортой хөгжлийн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулах	
ҮЧҮ-7: Агаар, орчны бохирдол	23. Орчны бохирдлыг бууруулах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	ХОХБТХ, ХХААГ, УЦУОША, ГХБХБГ, Сумдын ЗДТГ, иргэд, бусад төрийн болон ТББ
	24. Орчны бохирдлыг бууруулах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах	
	25. Агаар, усны чанар, орчны бохирдлын төлөв байдлыг үнэлэх, мэдээллээр хангах	
	26. Химийн хорт болон аюултай бодисын бодлого, зохистой менежмент, хууль тогтоомж ийг хэрэгжүүлэх	
	27. Химийн хорт болон аюултай бодисын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах	
ҮЧҮ-8: Газрын доройтол, цөлжилтийг сааруулах бодлого	28. Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	ХОХБТХ, ХХААГ, УЦУОША, ГХБХБГ, Сумдын ЗДТГ, иргэд, бусад төрийн болон ТББ
	29. Газрын доройтлыг бууруулах, эвдэрсэн газар, газрын хэвлийг нөхөн сэргээх үйл ажиллагааг зохицуулах	
	30. Ашигт малтмалын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	
	31. Цөлжилт, газрын доройтлыг бууруулах	

	зорилгоор ойжуулах.	
ҮЧҮ-9: Хог хаягдлын менежмент	32. Хог хаягдлын менежментийг сайжруулах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	
	33. Хог хаягдлын менежмент, эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг зохицуулах	
	34. Аюултай хог хаягдлын менежментийг зохицуулах	
Ерөнхий чиг үүрэг-3: Аялал жуулчлал		
ҮЧҮ-10: Аялал жуулчлалын хөгжлийн бодлого	35. Аялал жуулчлалын бодлого, хууль тогтоомжийг эрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	ХОХБТХ, Сумдын ЗДТГ, иргэд, бусад төрийн болон ТББ
	36. Аялал жуулчлалын хөрөнгө оруулалтын бодлогыг орон нутагт зохицуулах, хээржүүлэх	
	37. Хүний нөөцийн хөгжлийн бодлого, сургалтын хөтөлбөрийг боловсруулах, батлуулах	
	38. Аялал жуулчлалын байгууллага, үйлчилгээний байгууллагын стандартын, хэрэгжилтийг хянах	
	39. Аялал жуулчлалын байгууллагуудад зөвшөөрөл олгох, цуцлах	

Гурав. Алсын хараа

Ногоон хөгжлийг эрхэмлэн, иргэдийн оролцоонд тулгуурлан экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалсан говийн бүсийн тэргүүлэх аймаг болно.

Дөрөв. Эрхэм зорилго

Иргэдийнхээ эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм эдийн засгийн хөгжлийг ногоон баримжаатайгаар байгаль орчны тэнцвэрт байдалтай уялдуулах, байгаль орчныг хамгаалах, түүний нөөц баялгийг зохистой ашиглах, жам ёсоороо нөхөн сэргээх боломжийг бүрдүүлэхэд орон нутгийн удирдлага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагаа, санаачлагыг чиглүүлэх, салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан ажиллах

Тав. Орчны шинжилгээ

Монгол Улсын Үндсэн хуульд заасанчлан байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авч, орчны бохирдлыг бууруулж иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд үндсэн үйл ажиллагаагаа чиглүүлж, төр, иргэд, хувийн хэвшлийн болон бусад байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлж, төрийн үйлчилгээг мэргэжлийн түвшинд цаг үеэ олсон, ил тод, нээлттэй, хүнд сурталгүй, чанартай шуурхай хүргэхийн төлөө бүхий л боломж нөөцөө зориулан ажиллана.

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дотоод болон гадаад орчин ихээхэн нөлөөтэй тул эдгээр орчин нөхцөлийг байнга хянаж, сайжруулж ажиллана. Үүнд:

Дотоод орчин:

- Төрийн албаны тухай хууль, тогтоомжийг чанд мөрдөж, мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, тогтвортой, ил тод, хариуцлагатай байх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх шаардлага тавьж, хууль, тогтоомжид заасны дагуу цалин

хөлсийг нэмэгдүүлэх, албан тушаалын зэрэглэл ахиулах, дэвшин ажиллах нөхцөл, нийгмийн баталгаагаар хангах;

- Үйл ажиллагаагаа саадгүй явуулахад нийцсэн бодлого, эрх зүйн орчин бүрдүүлэх;
- Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагч бүрийн үүрэг, хариуцлагыг тодорхой болгох;
- Мэргэжилтний ур чадвар, бүтээлч санаачилга, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх;
- Үйл ажиллагааг эрэмбэлэх шалгуур үзүүлэлт гаргаж мөрдөх;
- Газар, хэлтэс, хувь хүмүүс хоорондоо хамтран ажиллаж, мэдлэг, мэдээллээ харилцан солилцох, ур чадвараасаа суралцах;
- Бүх газар, хэлтсийн ажлын уялдаа, холбоог сайжруулах;
- Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагч бүрд төрийналбанхаагчийн нөсзүйн хэмжээг сахин мөрдүүлж, хамтолны дотор ажил хэрэгч сэтгэл зүйн уурамьсгалыг бүрдүүлэх;
- Байгууллагын дотоод мэдээлэл хуваалцах, түгээх, харилцах цахим системийг боловсронгуй болгож, шуурхай, найдвартай ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдлыг хангах;
- Яамны байрыг ногоон хэв загвар бүхий жишиг барилга болгон шинэчилж, ажилчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах;
- Онцгой нөхцөл байдлын үеийн заавар, зөвлөмжийг дагуу шуурхай ажиллагааг хангаж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх;
- Олон нийтэд нээлттэй, шуурхай мэдээлэл, үйлчилгээгээр хангах нэг цэгийн үйлчилгээг боловсронгуй болгох.

Гадаад орчин:

- Мэдээллийг нээлттэй байлгах, харилцан солилцох.
- Орон нутгийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах
- төрийн байгууллагуудын байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжил, тогтвортой хөгжлийг дэмжих бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохицуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;
- Үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай хүний болон санхүүгийн нөөцийг бүрдүүлэх;
- Төрийн бус байгууллага, иргэний нийгэм, хувийн хэвшил тэдгээрийн үүрэг, хариуцлага, оролцоог тодорхой болгох;
- Байгууллагын манлайлал, үйл ажиллагаа, үйлчилгээг харилцагч талууд, олон нийтэд ойлгуулан сурталчлах;
- Мэдээллийг нээлттэй байлгах, харилцан солилцох.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дотоод, гадаад орчны шинжилгээний үр дүнг нэгтгэх СВОТ хүснэгт

ДОТООД ОРЧИН	
Давуу тал	Сул тал
1. Бүтэц, зохион байгуулалт, ажиллах орчин нөхцөл	

<ul style="list-style-type: none"> - Хуулиар олгогдсон чиг үүргүүд нь тодорхой - Компьютер, техник хэрэгслийн хангамж сайн - Мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх боломжтой 	<ul style="list-style-type: none"> - Мэргэжилтэй боловсон хүчин дутагдалтай. - Батлагдсан орон тоондоо багтааж, давхар ажил гүйцэтгэдэг. - Албаны зориулалтын байргүй - Төсөв хүрэлцдэггүй.
<p>2. Төлөвлөлтийн систем</p>	
<ul style="list-style-type: none"> - Тогтоосон журмын дагуу төлөвлөлт хийгддэг. - Байгууллага дотроо уялдаа холбоо сайн - Аймгийн хүн ам цөөн, нутаг дэвсгэрийн байдлын онцлогоос хамаарч ажлууд бусад аймгийг бодвол харьцангуй сайн 	<ul style="list-style-type: none"> - Иргэдийн санал, санаачилга тусгах байдал - Салбар дундын уялдаа холбоо сул - УИХ, Засгийн газраас батлагдсан байгаль орчныг хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх, чиглэлээр баримтлах бодлого, хөтөлбөр, менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр дутмаг, давхардсан агуулга бүхий хэт болон бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангахад хүндрэл үүсэж байгаа тул нэгдсэн бодлого шаардлагатай.
<p>3. Хяналтын систем</p>	
<ul style="list-style-type: none"> - Ажилтнуудын гүйцэтгэлийг төлөвлөгөөний үр дүнг хагас, бүтэн жилээр тооцож үнэлж дүгнэж байна. - Төсвийн шууд захирагч гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, гүйцэтгэлийг үнэлж, дүгнэдэг. - Дотоод аудитыг хийж хэвшиж байна. 	<ul style="list-style-type: none"> - Дотоод хяналт харьцангуй сул - Өмнөх онуудад хийгдсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны гүйцэтгэл, гадаадын зээл тусламжийн хүрээнд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн үр дүнгийн тайлан мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, шинээр төлөвлөгдсөн төсөл арга хэмжээний давхцлыг хянах механизм бүрдүүлэх шаардлагатай.
<p>4. Удирдлагын бүтэц, боловсон хүчний чадавхи</p>	
<ul style="list-style-type: none"> - Ажиллаж буй боловсон хүчний чадавхи, мэргэшлийн ур чадвар тавигдаж буй шаардлагыг хангаж байна. - Цомхон учраас цаг хугацаа хэмнэж, ур чадвар эзэмшүүлэхэд таатай байдаг. - Төрийн албаны хуулинд сургах, мэргэшүүлэх зохицуулалт оруулж, сургалтын мэргэшлийн байгууллагатай болсон. 	<ul style="list-style-type: none"> - Шийдвэр гаргах үйл явц удаан - Мэргэжил дээшлүүлэх богино болон урт хугацааны сургалтуудад хамрагдах - Албан хаагчид өөрсдөө мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх идэвхи чармайлт - Баг болж ажиллах чадвар сул - Цаг хугацаанд нь үүрэг даалгаврыг биелүүлэх байдал сул - Ажлаа хариуцах чадвар сул

5. Урамшууллын тогтолцоо

Албан хаагчдын ажлын үр дүн, мэргэшлийн түвшин, ур чадвар, санаачилга, хариуцлага, сахилга бат зэргийг харгалзан ЗГ болон төрийн дээд байгууллагаар шагнуулахаар тодорхойлох, байгууллагын шагналаар шагнаж урамшуулдаг.

ГАДААД ОРЧИН

Боломж

Эрсдэл

1. Улс төрийн хүчин зүйл

- Нутгийн удирдлагын түвшинд улс төрийн тогтвортой байдал бий болсон нь бодлогын хэрэгжилтийг хангахад эерэг нөлөө үзүүлж байна.

- Бусад байгууллагын чиг үүргийг холилдуулах хандлагатай.

- Аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчдийн байгаль орчны салбарын хууль тогтоомжийн талаар мэдлэг, ур чадвар дутмаг байдал

Аймгийн ИТХ, Засаг дарга, түүний ажлын албаны бодлого чиглэл

- БОАЖ-ын салбарыг хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлэн тавьсан бодлогын санал, хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

- Төсөв санхүү хүрэлцээгүй, хөрөнгөгүй олон ажил төлөвлөгддөг.

- Хэтэрхий олон үндэсний хөтөлбөр баталдаг. Төсөв хөрөнгөгүй, давхардал ихтэй.

- Салбарын БХНСАХЗ-ын төсөв жилээс жилд буурч ирсэн.

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажилладаггүй.

5. Нийгэм, эдийн засгийн байдал

- Дэд бүтэц, төмөр зам, тээвэр логикийн давуу талаа ашиглан аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж

- Мэдээллийн технологи, харилцаа холбоо сайн хөгжсөн.

- Байгалийн болон соёлын өвд тулгуурлан богино хугацааны аялал жуулчлалыг хөгжүүлэх

- Дорноговь, Хэнтий, Өмнөговь зэрэг аялал жуулчлалын улсын маршрутын дайран өнгөрөх гол төв болж эдийн засгийн бүтцийг солонгоруулах, аялал жуулчлалын үйлчилгээний салбарын өсөлтийг хангах замаар өрхийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой.

- Аливаа эрсдэл, давагдашгүй хүчин зүйл үүсэхэд түүнийг давар туулах нөөц, боломж бий болгож чадаагүй

- Зах зээлийн хүртээмж бага

- Цар тахлын тархац, түүнээс үүдэлтэй эдийн засгийн сааралт, түүнээс үүдэлтэй ажилгүйдэл;

- Хүн амын хэт төвлөрлөөс үүдсэн хөрс, утаа орчны бохирдол их;

- Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагавар;

- Цэвэрлэх байгууламж байхгүй

- Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болсон зүрх судас, хорт хавдрын өвчлөл, нас баралт өндөр

- Бэлчээрийн даац хэтэрсэн

- Гадаад харилцаа муу

6. Ажиллах орчин нөхцөл

- Ажиллах нөхцөл харьцангуй сайн

- Зориулалтын албаны байргүй

Зургаа. Стратегийн зорилго

Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэн, байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлж, орон нутагтаа тэргүүлэх салбар болно.

Найм. Стратегийн зорилго ба Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын нэгж, байгууллагын бүтцийн уялдаа, зураглал

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг Засгийн газрын 2020 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 71 дүгээр тогтоолоор баталсан.

Мөн Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 121 дүгээр тогтоолоор “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Усны газар”-ыг байгуулж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн А/561 дүгээр тушаалаар “Агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийг, Засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 182 дугаар тогтоолоор “Байгаль орчны судалгаа, шинжилгээний төв” Улсын төсөвт үйлдвэрийн газрыг байгуулж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн А/584 дүгээр тушаалаар “Байгаль орчны судалгаа, шинжилгээний төв” Улсын төсөвт үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар”-ыг тус тус баталсан.

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт улсын төсвөөс санхүүждэг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, түүний харьяа Цаг уур, орчны шинжилгээний газар, Усны газар болон Байгаль орчин, уур амьсгалын сан, Ойн судалгаа, хөгжлийн төв, Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв, Байгаль орчны судалгаа, шинжилгээний төв улсын төсөвт үйлдвэрийн газар, Улсын тусгай хамгаалалттай газрын 30 хамгаалалтын захиргаа, гол, нуурын 21 Сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн Цаг уур, орчны шинжилгээний 26 газар зэрэг 82 байгууллага, Монгол Ус, Монгол кувейт, Аялал жуулчлалын хөгжлийн төв гэсэн 3 төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, хувийн хэвшил менежментийн гэрээгээр хариуцан ажиллаж байгаа улсын тусгай хамгаалалттай газрын 4 хамгаалалтын захиргаа, аймаг нийслэлийн Засаг даргын тамгын газрын дэргэдэх 22 Байгаль орчин, аялал жуулчлалын газрууд ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар Улсын төсвийн 82 байгууллагад нийт 2,922 албан хаагч ажиллаж байна. Үүнээс 1893 албан хаагч цаг уур, орчны шинжилгээний салбарт, улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаадад 607 албан хаагч, гол, нуурын сав газрын захиргаадад 200 албан хаагч, яаманд 121 албан хаагч, усны газарт 20 албан хаагч, улсын төсөвт үйлдвэрийн 2 газарт 37 албан хаагч ажиллаж байна.

Салбарын байгууллагын бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг, үйл ажиллагааны уялдааг хангах нэгдсэн архитектур зураглалыг дараах байдлаар боловсруулж, бүтцийн схем 1, бүтцийн схем 2 –т тус тус оруулсан.

Долоо. Стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, стратеги
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2021-2024 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги (арга зам)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2020 он)	Зорилтот түвшин (2021-2024)	Санхүүгийн эх үүсвэр, сая.төг	Хамртан хэрэгжүүлэх байгууллаг ууд
Ерөнхий чиг үүргийн нэр: Байгаль орчныг хамгаалах							
Үндсэн чиг үүргийн нэр: Газар, ландшафт							
1.	Зорилт-1. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх	Газрын доорх цэнгэг усны орд газруудыг орон нутгийн тусгай хамгаалалтад авах ажлыг зохион байгуулах Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	Орон нутгийн тусгай хамгаалалтад авсан орд газрын тоо		7		ХОХБТХ, БОАЖГ, ГХБХБГ
2.			Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь	37	45	-	АЗДТГ, СЗДТГ, БОАЖГ, ГХБХБГ
3.		Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих	Хууль тогтоомжийн хэрэгжилт	-	100 хувь		АСЗДТГ БОАЖГ БНХМНөхө рлөл
4.	Зорилт-2 Нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгаалал, байгалийн нөөцийн	Олон талт байгаль хамгааллын менежментийг нэвтрүүлж, тусгай хамгаалалттай газар, ойн сан бүхий газрын	Гэрээгээр эзэмшин хамгаалж байгаа ойн сангийн талбай	1. 4.5 сая.га	1. 6 сая.га		АСЗДТГ, БОАЖГ Иргэдийн нөхөрлөл,

хамтын менежментийг хэрэгжүүлэх	хамгааллын үр ашигтай байдлыг сайжруулах					Ойн анги
---------------------------------	--	--	--	--	--	----------

Ерөнхий чиг үүргийн нэр: Байгаль орчныг хамгаалах

Үндсэн чиг үүргийн нэр: Усны бодлого

5	Зорилт-1. Усны нөөцийг бохирдол, хомстлоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, баталгаат ундны усаар хангасан хүн амыг 85 хувьд хүргэнэ.	Усны сан бүхий хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэх	Усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсийн дэглэмийн хэрэгжилт Эрүүл ахуйн бүс тогтоосон эх үүсвэрийн тоо	4	Усны сан газар, усны үүсвэрийн хамгаалалт сайжирч, баталгаат байдал хангагдсан байна. 20	ОНТ	Ус олборлон түгээх тусгай зөвшөөрөлтэй байгууллагууд, СЗДТГ, БОАЖГ, АЗДТГ, МХГ
6		Булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг үргэлжлүүлж хур бороо, цас, мөсний усыг хуримтлуулах, усан сан, хөв, цөөрөм байгуулах	Хашиж хамгаалсан булаг, шандны тоо Зарцуулсан хөрөнгө	2 12.0	5 30.0	БХНСАХЗ Сумдын ОНХС	БОАЖГ, ХХААГ, Сумдын ЗДТГ
7		Аймаг, сумдын төвийн ундны усны эх үүсвэрт нөөцийн судалгаа хийнэ.	Нөөцийн судалгаа хийсэн тоо	-	2	УТ	БОАЖГ, АЗДТГ
8		Хот, суурин газрын хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийг тогтоох хайгуул, судалгааны ажлыг хийх	Нөөц нь тогтоогдсон эх үүсвэрийн тоо	1	16	УТ ОНТ	АСЗДТГ БОАЖГ
		Аймгийн төвийн айл өрхүүдийг	Шөнийн тарифын	89	10013	УТ,	БОАЖГ,

	ухаалаг тоолуур, гэр хорооллын айл өрхүүдэд утаагүй түлшний хэрэглээг нэвтрүүлж, цахилгааны шөнийн тарифын хөнгөлөлтийг үзүүлж, агаарын бохирдлыг бууруулна.	хөнгөлөлт үзүүлсэн өрхийн тоо Ухаалаг тоолуураар хангагдах өрхийн тоо	2310	ГЗТ	БЗӨБЦТ ТӨХК-ийн Говьсүмбэр салбар, СЗДТГ
--	--	--	------	-----	--

Ерөнхий чиг үүргийн нэр: Байгаль орчныг хамгаалах

Үндсэн чиг үүргийн нэр: Ойн бодлого

9	Зорилт-1 Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг 8.6 хувьд хүргэнэ.	Хэрлэн гол дагуу байрших байгалийн ойн санг хамгаалах	Цөвөрлэгээ хийсэн талбай га 10, нөхөн тарилт хийсэн талбай га	2	10	-	Сум дундын ойн анги
10		Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн хамгаалалтыг сайжруулж, нэмэгдүүлэх	25 га-аар нэмэгдүүлсэн байна.	5 га	87.3 га	БХНСАХЗ , Гадаад тусламжо НХС	АСЗДТГ, ААНБ, СДОА
11		Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор мод бут тарьсан иргэн, ААНБ-д мөнгөн урамшуулап олгох.	Нийтийн эзэмшлийн талбайд мод, бут тарьсан иргэн, ААНБ-д урамшуулап олгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.	Урамшуулап олгосон 18.9 сая төгрөг Иргэний тоо- 12, ААНБ-ын тоо- 4	Урамгуулап олгосон Иргэний тоо ААНБ-ын тоо	БХНСАХЗ ОНХС	СЗДТГ

Ерөнхий чиг үүргийн нэр: Байгаль орчныг хамгаалах

Үндсэн чиг үүргийн нэр: Биологийн олон янз байдлын бодлого

12	Зорилт-1 Ховор амьтан, ургамлыг зориудаар өсгөн үржүүлж, ашиглалтын нөөц бий болгоно.	Нэн ховор, ховор амьтан, ургамлын нөөц, ховордсон зүйлийг хамгаалж, нутагшуулж, ургамлыг тарималжуулах.	Тархац нөөцийг тогтоосон ашиглалтад өртөмтгий амьтан ургамлын тоо	Биотехникийн арга хэмжээ: Давтамжийн тоо: 4 Өвс боодол: 134 Хужир тонн: 1.5 тонн Хамрагдсан хүний тоо 200 гаруй Ган тэсвэртэй 10 төрлийн 1000 гаруй мөчир, 10 кг хонхорт харганы үр, 2000 ширхэг хайлаас суулгацаар тарьсан.	Нутагшуулсан амьтаны тоо: Биотехникийн арга хэмжээ: Тарималжуулж, нутагшуулсан ургамлын тоо	ОНХС БХНСАХ 3	АЗДТГ, СЗДТГ, Хувийн хэвшил Гадаадын хөрөнгө оруулалт Иргэдийн нөхөрлөл
13		Ашиглалтад өртөмтгий амьтны тархац нөөцийг үе шаттайгаар хамгаалах	Тархац нөөцийг тогтоосон ашиглалтад өртөмтгий амьтаны тоо	2019 онд 50 тоо толгой тарвага нутагшуулс ан.		УТ, ОНТ Гадаадын зээл, тусламж	АЗДТГ, СЗДТГ, Хувийн хэвшил
Ерөнхий чиг үүргийн нэр: Байгаль орчныг хамгаалах							
Үндсэн чиг үүргийн нэр: Салбарын нэгдсэн удирдлага зохион байгуулалт							
14	Зорилт-1: Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим орчныг бүрдүүлэн, ил тод байдлыг ханган, иргэд, олон нийтэд мэдээ, мэдээлэл, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх орчин нөхцлийг бүрдүүлнэ	Мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэн, дотоод удирдлагын ERP системийг нэвтрүүлнэ	“Мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	БОАЖГ	
15	Зорилт-2:	Аймгийн Засаг дарга, нутгийн захиргааны байгууллагуудад	Өргөдөл, гомдлыг хүлээн авч,	1.		БОАЖГ	

	Нутгийн захиргааны байгууллагууд	иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, хугацаанд нь шийдвэрлэх.	хугацаанд нь шийдвэрлэсэн хувь				
16	<p>чадавхжуулж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, төрийн албан хаагчдын ёс зүй, хариуцлагыг дээшлүүлнэ.</p>	<p>Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.</p>	<p>Иргэдэд зохион байгуулсан сургалт, сурталчилгааны тоо; Хамрагдсан иргэд Албан хаагчдад зохион байгуулсан сургалтынтоо; Хамрагдсан төрийн албан хаагчдын тоо;</p>	<p>5 200 8 9</p>	<p>20 400 30 12*4</p>	<p>Байгуулл агын төсөв</p>	<p>БОАЖГ</p>
17	<p>Зорилт-3 Салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, хүний нөөцийн эрэлт, хэрэгцээний судалгаа хийх</p>	<p>1. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлого хэрэгжүүлэх</p>	<p>2. Хүний нөөцийн эрэлт, хэрэгцээний судалгаа</p>	<p>-</p>	<p>Хүний нөөцийн эрэлт, хэрэгцээний судалгааг нэгтгэн, тэргүүлэх чиглэлийг жил бүр тогтоосон байна.</p>		<p>БОАЖГ</p>
18		<p>2. Төрийн албан хаагчийн ажиллах, нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх</p>	<p>Хөтөлбөрийн хэрэгжилт, хувь</p>	<p>-</p>	<p>80-иас доошгүй</p>	<p>УТ</p>	<p>БОАЖГ</p>

Ерөнхий чиг үүргийн нэр: Орчны бохирдол, доройтлыг бууруулах

Үндсэн чиг үүргийн нэр: Тогтвортой хөгжил, ногоон хөгжил

19	Зорилт-1 Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг 12.3 хувиар бууруулна.	Тогтвортой хөгжлийн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулах	Тогтвортой хөгжлийн боловсрол олгох чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний тоо	9	20		БОАЖГ
20	Зорилт-3 Аж ахуйн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг гүнзгэр, сөрөг нөлөөллийг бууруулах	Уул уурхай, боловсруулах, баяжуулах үйлдвэрлэл болон бусад төслүүдэд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, аудит хийж, бохирдол багатай, нөөцийн хэмнэлттэй технологи нэвтрүүлж, байгаль орчны бохирдол, доройтлыг бууруулах	1. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгүүлсэн төслийн тоо 2. Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн төслийн тоо	5 2	20	ААН-ийн хөрөнгө	БОАЖГ
21	Зорилт-2 Хаягдал багатай, цэвэр хэмнэлттэй технологийг, тогтвортой үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах	Уул уурхайн төслийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх, хяналт тавих	Нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ		20 га-аас доошгүй	ААН-ийн хөрөнгө	МХГ, БОАЖГ
22	Зорилт-2 Хаягдал багатай, цэвэр хэмнэлттэй технологийг, тогтвортой үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах	Байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй техник, технологи, үйлдвэрлэл эрхэлж буй иргэн, ААН байгууллагын тоог нэмэгдүүлэх	Ногоон шошго, гэрчилгээ авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тоо, жилээр				АЗДТГ, БОАЖГ

Ерөнхий чиг үүргийн нэр: Орчныбохирдол, доройтлыг бууруулах

Үндсэн чиг үүргийн нэр: Агаар, орчны бохирдол

23	Зорилт-1 Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 80 хувь хүртэл бууруулж, бусад томоохон хот, суурин газрын агаарын бохирдлын асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.	Агаар, орчныг бохирдуулж байгаа эх үүсвэрийн тооллого судалгаа явуулж, иргэд олон нийтийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, цогц арга хэмжээ авах	Тооллого явуулсан байдал Мэдээлэл хүргэсэн тоо Сургалтын тоо Хамрагдсан иргэн, албан хаагч	20 6 121	-	БОАЖГ, Сумдын ЗДТГ, УЦУОШТ,
24		Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Үндэсний хөтөлбөр хэрэгжилт	Хэрэгжилт 88%	Хэрэгжилтийн хувь	Улсын төсөв, ОНХС, БОАЖГ, УЦУОШТ
25		Агаарын чанарыг 3-аас доошгүй үзүүлэлтээр хянах боломжийг бүрдүүлэх	Агаарын бохирдлыг 3-аас доошгүй үзүүлэлтээр тасралтгүй, автоматаар хянах боломжийг бүрдүүлсэн байдал	-	УТ, ОНТ, Гадаадын зээл, тусламж	ЦУОШГ, АНЗДТГ, БОАЖГ
26	Зорилт-2	Суурьшлын бүс болон гэр хорооллын бүсэд байгаа хөрс бохирдуулагч жорлонгийн тоог үе шаттайгаар бууруулах арга хэмжээг авах			80	АЗДТГ, СЗДТГ, БОАЖГ, МХГ
27	Агаар, усны чанар, орчны бохирдлын төлөв байдлыг үнэлэх, мэдээллээр		Стандартын шаардлага хангасан жорлонгийн тоо	3		

хангах									
Ерөнхий чиг үүргийн нэр: Орчны бохирдол, доройтлыг бууруулах									
Үндсэн чиг үүргийн нэр: Газрын доройтол, цөлжилтийг сааруулах бодлого									
28	Зорилт-1. Хөрс хамгаалах, цөлжилттэй бодлого, тогтоомжийг боловсронгуй хэрэгжилтийг зохицуулах	Цөлжилтийг сааруулах элсний нүүлтээс хамгаалах, хамгаалалтын зурвас байгуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх	Хамгаалалтын зурвас бий болгосон талбай	5 га	25 га	УТ, ОНХС БХНСАХЗ	АЗДТГ, СЗДТГ, Хувийн хэвшил		
29	Зорилт-2 Газрын доройтлыг бууруулах, газрын нөхөн сэргээх үйл ажиллагааг зохицуулах	Уул уурхайн улмаас эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийнэ.	Нөхөн сэргээсэн талбай /уул уурхай/, га	4	18	БТ	БОАЖГ, АЗДТГ, СЗДТГ, ААНБ-УУД		
30	Зорилт-2 Газрын доройтлыг бууруулах, эвдэрсэн газар, газрын хэвлийг нөхөн сэргээх үйл ажиллагааг зохицуулах	Аймгийн хэмжээнд байгаа эвдэрсэн газруудыг үе шаттайгаар нөхөн сэргээх Нөхөн сэргээсэн газар нутгийн хэмжээ, га Зарцуулсан хөрөнгө Хамрагдсан ААН-ийн тоо	Нөхөн сэргээсэн газар нутгийн хэмжээ, га Зарцуулсан хөрөнгө Хамрагдсан ААН-ийн тоо	10	40 га-аас доошгүй	60.0 ОНТ, /хувийн хэвшил/	МХГ, ХОХБТХ, БОАЖГ, Сумдын ЗДТГ,		
		Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаанд хяналт тавьж нөхөн сэргээлт хийлгэх	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн хувь	-	50-аас доошгүй хувь	ОНТ /хувийн хэвшил/	МХГ, Сумдын ЗДТГ, БОАЖГ, ЭЦА		

Ерөнхий чиг үүргийн нэр: Орчны бохирдол, доройтлыг бууруулах

Үндсэн чиг үүргийн нэр: Хог хаягдлын менежмент

31	Зорилт-1 Хог хаягдлын менежментийг сайжруулах бодлого, хууль тогтоомж боловсронгуй болгож, хэрэгжилтийг ханган эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг зохицуулах	Хог хаягдлын менежментийг дахин хог хаягдлын менежментийг сайжруулах, боловсруулах болон тусгай хог хаягдлыг цуглуулах байгуулах	Дахин боловсруулсан хог хаягдлын эзлэх хувь	0.03%	1%	АЗДТГ, БОАЖГ, Хувийн хэвшил
		Аймаг, сумдын төвийн хог хаягдлын менежментийг сайжруулан, ахуйн болон туурь хог хаягдал бүхий талбайг үе шаттайгаар бууруулж, аймгийн төвд ландфилл технологийг сайжруулна.	Хог хаягдал цэвэрлэсэн талбайн хэмжээ, га	11га	40га	БОАЖГ, СЗДТГ, Тохижилт сүмбэр ОНӨААТҮГ, ААНБ-ууд
32	Зорилт-2 Аюултай хог хаягдлын менежментийг зохицуулах	Аюултай хог хаягдлын төвлөрсөн түр хадгалах байгууламж байгуулах	Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламжийн бүтээн байгуулалтын ажлын хувь	Сүмбэр суманд 2.5 га газрыг “Аюултай хог хаягдал түр хадгалах” зориулалтаар олгосон.	Аюултай хог хаягдал түр хадгалах байгууламж бий болсон байна.	АЗДТГ, БОАЖГ, СЗДТГ, МХГ

Ерөнхий чиг үүргийн нэр: Аялал жуулчлал

Үндсэн чиг үүргийн нэр: Аялал жуулчлалын хөгжлийн бодлого

33	Зорилт-1 Аялал	Байгаль, түүх, соёлын аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийг тогтмол зохион	Эвент арга хэмжээний тоо	-	3	БОАЖГ
----	-------------------	--	--------------------------	---	---	-------

	байгуулж, цар хүрээг өргөжүүлэх						
34	жуулчлалын хөгжлийн бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, жуулчдын тоог нэг саяд хүргэнэ.	Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгох	Бий болгосон бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо	2	4	БОАЖГ	
35	Аялал жуулчлалын үйлчилгээний ажилтан, албан хаагчдыг хүний нөөцийг чадавхижуулах	Чадавхжуулах сургалтын тоо	Сургалтанд хамрагдсан иргэдийн тоо	1	3	ОНХС БХНСАХЗ	БОАЖГ ХХҮГ АЖХ Хувийн хэвшил
36	Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, түншлэлийн холбоог сайжруулах	Хамтран ажилласан арга хэмжээний тоо		2	6	ОНХС	АЗДТГ СЗДТГ БОАЖГ АЖХ Хувийн хэвшил
37	Орон нутгийн онцлолт тохирсон тусгай сонирхлын аялал жуулчлал хөгжүүлэх	Аяллын төрлийн тоо		1	3	ОНХС БХНСАХЗ	
38	Зорилт-15: Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хууль, тогтоомжийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр Засаг дарга, нутгийн захиргааны байгууллагуудыг бодлого, зөвлөгөө, мэдээллээр хангаж, мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлэх	Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын багц хууль, төрийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын хэрэгжилт, хувь	90	100	-	БОАЖГ
39		Байгалийн нөөц, баялагийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	5	30	БХНСАХЗ ОНХС	БОАЖГ
		Нөхөн сэргээсэн талбай, га		10	40		